



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 1/557

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1(а), 29.1.2(а), 29.1.4(в), 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 08 дугаар сарын 28-ны 74 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2018-2019 оны өвлийн бэлтгэл ажлын хүрээнд аваарийн байдалтай 3 дугаар хорооллын ТП-232 станцаас ТП-234 дэд станц хүртэл 6 кв-ын кабель шугам, 9 дүгээр цэцэрлэгийн гадна дулааны шугам, мөн эвдрэл ихтэй гудамжнуудад авто замын нөхөөс хийх ажлын хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх ажилд шаардагдах 57443900 /Тавин долоон сая дөрвөн зуун дөчин гурван мянга есөн зуун/ төгрөгийг болзошгүй аваарийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2018 оны  
09 дүгээр сарын 22-ны өдрийн  
557 дүгээр захирамжийн хавсралт



**БАРИЛГЫН ЗАСВАРЫН АЖЛЫН  
ЗАРДАЛ**

Д/д	Зардлын нэр	Зардал /төгрөг/	Тайлбар
1	3 дугаар хорооллын ТП-232 станцаас ТП-234 дэд станц хүртэл 6 кв-ын кабель шугам шинэчлэх ажил	32200000	6кв-ын кабель шугам авах материалын зардал
2	9 дүгээр цэцэрлэгийн гадна дулааны шугамын засварын ажил	20243900	Гэмтэлтэй шугам сүлжээг засварлах
3	Авто замын нөхөөс хийх	5000000	Шинэ технологиор авто замын нөхөөс хийх
Нийт		57443900	